

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.10.10 - 2022.10.14/

2022.10.07

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилга угсралтын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Засгийн газрын 213-р тогтоолын дагуу 1 барилга байгууламжид ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулж ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Малтай иргэдийг суурьшуулах шинэ суурьшлийн бүсийн 0,4кВ, 6кВ-ын агаарын шугам, 250 кВа дэд өртөөний гадна цахилгаан хангамжийн ажлын барилга. ✓ Засгийн газрын 212-р тогтоолын дагуу 2 барилга байгууламжид барилгын ажлын эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгосон. Үүнд: <ul style="list-style-type: none"> - “Номин реалтор” ХХК-ний 36м х 60м хэмжээтэй зоорьгүй 2 давхар үйлчилгээний барилга - “Шунхлай петролиум” ХХК-ний шатахуун түгээх станцын барилга. ✓ Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авалгүй барилга угсралтын ажил хийж байсан 3 барилга байгууламжийн барилгын ажлыг зогсоож холбогдох хуулийн дагуу арга хэмжээг авсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р багт байрлалтай “Атаман Стил” ХХК үйлдвэр - Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р багт байрлалтай “Мон росрапс” ХХК агуулах - Дархан-Уул аймаг, Дархан сум, 14-р багт байрлалтай иргэн П.Фрунз зочид буудал ✓ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас 2021-2022 онуудад улсын төсвийн оруулалттай 3 барилга байгууламжид захиалагчийн техник хяналтыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Орхон суманд 150 тонны агуулахын барилга / Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар / МОН-9192 төсөл / ГҮЙЦЭТГЭГЧ: “Смарт грийн девелопмент” ХХК, АЖЛЫН ЯВЦЫН ХУВЬ: 60% - Орхон суманд ногоо боловсруулах, савлах цехийн барилга / Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар / МОН-9192 төсөл / ГҮЙЦЭТГЭГЧ: “ГЭЭТ” ХХК, АЖЛЫН ЯВЦЫН ХУВЬ: 55% - 2200 хүний суудалтай спорт цогцолборын барилга “НЭМБАР” ХХК, “ХИМОН КОНСТРАКШН” ХХК ТҮНШЛЭЛ, АЖЛЫН ЯВЦЫН ХУВЬ: 91%
1	Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Дархан-Уул аймгийн 13-р баг 29-р хороололд төлөвлөж буй Залуус 1 хорооллын ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлж буй Инженер геодези ХХК -ны төлөвлөлтийн танилцуулгад оролцсон. Аймгийн ХБТХОХ, инженерийн хангагч байгууллагууд оролцсон. ✓ Дархан сумын 6,15-р багийн нутаг дэвсгэрт хийгдэх гэрэлтүүлгийн ажлын барилгын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон. ✓ Дархан хотыг цахилгааны эрчим хүчээр найдвартай хангах ажлын хүрээнд цахилгааны шугамыг цагираг сүлжээнд холбох талаар ЦДҮС ТӨХК -ны шугамын трасс, цахилгаан станцын байршилыг тогтсон.
	Барилгын материал үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> ✓ Аймгийн хэмжээнд Бетон зуурмагийн үйлдвэрүүдийн хяналтын лабаораторийн мэдээг марк тус бүрээр, тоног төхөрөөмжийн баталгаажилтын хуулбарыг хамт судалгааг авсан. / Анто-од ХХК, Сонголон хайрхан ХХК/ <p>Стандарт стийл ХХК, Их торгоны зам ХХК –ний мэдээлэл ирээгүй байна.</p>
Газрын удирдлагын хэлтэс		
1	Суурь судалгаа, газрын мониторинг	<ul style="list-style-type: none"> ✓ Захиалгат хянан баталгааны 24 тайлан баталгаажуулж 6 тайлан хянаж буцаасан. ✓ Гео инженеринг сүрвэй ХХК-д зөвлөмж хүргүүлж ажилласан.

2	Газрын кадастрын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудаар хэмжилт хийлгэсэн 4 иргэний материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. ✓ Газар Зохион байгуулалт, Геодези зураг зүйн газарт Зөрчилтэй нэгж талбарын зөрчил арилгах үйл ажиллагааг зохион байгуулж, авч хэрэгжүүлж байгаа ажлын явцын тайлан бичиж явууллаа. ✓ Өмчлөлийн газраа худалдах, өвлүүлэх, бэлэглэх гэрээгээр шилжүүлж байгаа нийт 8 иргэний цахим хүсэлтийг мэдээллийн санд өөрчлөлт хийж, кадастрын зургийг гаргаж өгсөн. ✓ Дархан-Уул аймгийн Орхон сумын 2-р баг Бүрэн толгойд зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож, нийт 24 иргэнд 13 төрлийн үйлчилгээ үзүүлж ажиллалаа. ✓ Дархан сумын Засаг даргын орлогч П.Ихбаяраар ахлуулсан ажлын хэсэгт орж Гэр хорооллын бүсээс мал, туслах аж ахуйг гаргах, зөвшөөрөлгүй буусан 1 малчин өрхөд газар чөлөөлөх шаардах хуудас хүргүүлж ажилласан.
3	Геодези, зураг зүйн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Хаягийн зургийн дагуу 13 иргэн, 2 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. ✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / хэмжилт хийлгэсэн 12 иргэн, 3 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. ✓ Хүсэлтийн дагуу Дархан сумын 10 дугаар багийн хилийн цэсийн зургийг хүргүүлэв. ✓ Шинэ хаягийн системийн дагуу хаягуулалт хийгдсэн сумдын судалгааг гаргаж ГЗБГЗЗГ-т албан бичгээр хүргүүлсэн.
4	Газар зохион байгуулалтын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, ААНБ -ын нийт 9 албан бичгийн лавлагааг газрын кадастрын системээс аймгийн хэмжээнд шүүж хариуг хүргүүлсэн. ✓ 2023 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршил, зориулалтыг аймгийн ИТ-ийн хурлаар оруулах ажлыг зохион байгуулсан. ✓ 2022-10-12 -ны өдөр гарсан аймгийн Засаг даргын захирамжаар гарсан хугацаа сунгах 2 нэгж талбар, эрх шилжүүлсэн 5 нэгж талбар, талбай хэмжээ өөрчлөгдөж байгаа 1 нэгж талбар нийт 8 иргэн хуулийн этгээдийн газар эзэмших гэрээг газрын кадастрын мэдээллийн санд үүсгэж ажилласан. ✓ ГЗБТ, ГӨ -ийн асуудал хариуцсан мэргэжилтэнд сургалтад хамрагдсан
Захиргаа аж ахуйн чиглэл		
1	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: 70376471 нээлттэй утсаар 3, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 5 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.</p> <p>Өрөөгөө сольж нүүдэл хийн, мэргэжилтнүүдийн 5 компьютерыг угсарч, сүлжээнд холбон ажиллахад бэлэн болгов. Суудал солигдсон тул 3 мэргэжилтний QR код бүхий хаягийн дугаарыг сольж хэвлэн наав.</p> <p>Байгууллагын номын сангаас шаардлагагүй номуудыг /198 ширхэг/ устгаж, агуулах руу зөөж тавив. Шинээр 13 ширхэг ном бүртгэж, бар кодыг хэвлэж наан, хураав. Номын сангийн номын судалгааны мэдээллийг шинэчлэн өөрчлөв.</p> <p>Агентлагаас зарласан 2 сарын аянаар сурталчлах ажлын саналыг албан хаагчдаас авч нэгтгэв.</p> <p>Мэдээллийн технологи: Байгууллагын цахим хуудасны Мэдээ, мэдээлэл цэсний Барилга, хот байгуулалт хэсэгт Орхон суманд баригдаж буй ногооны зорь, ногоо савлах цехийн барилга угсралтын ажилд хяналт тавьсан тухай мэдээг</p>

	<p>оруулав. Төрийн үйлчилгээ цэсний Газрын харилцаа хэсгийн мэдээллийг шинэчлэв.</p> <p>Байгууллагын бүх компьютерт хорт кодоос сэргийлэх програмыг шинэчлэн суулгав. Цаг бүртгэлийн төхөөрөмжид бүх албан хаагчдын код, нууц үгийн мэдээллийг оруулж, хүн бүрт код, нууц үгийг нь хэлж өгөн хэрхэн цагаа бүртгүүлэх зааврыг өгөв.</p> <p>Орхон сумын хөдөө багт зохион байгуулагдах нээлттэй хаалганы өдөрлөгт хэрэглэх 45 ширхэг брошурыг хэвлэж өгөв.</p>
--	--

Тайлан боловсруулсан:

Г.Нямдорж

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Г.Нямдорж